



БИЧГИЙН БА АМАН ЗОХИОЛЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АСУУДАЛД

(Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” болон
Амазоны домог үлгэрийн жишээн дээр)

Б.Мөнхбаяр¹

¹ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монгол улс
Цахим шуудан: bayar_pak@yahoo.com

Аман зохиол нь хүмүүсийн дунд уламжлагдан тархахдаа, нэг хүнээс олон хүнд дамжиж хүрч түгдэг, улмаар түүнийг хүлээн авсан сонсогч, авьяастнууд тээгч нь болж, хөгжүүлдэг буюу ерөөс хамтын сэтгэлгээний үр дүнд буй болсон бүтээл байдаг. Энэ бол үсэг бичгийн тэмдэглэл юм уу, хувь хүн өмнөхөөс залгамжилсан уламжлалаа нэг удаа илэрхийлсэн байдал, арга барилаас огт өөр зүйл билээ. Тиймээс аман зохиол, бичгийн зохиол хоёр нь дүрслэх арга, бүтэх зарчмын хувьд ихээхэн ялгаатай бие даасан бүтэц тогтолцоо байдаг. Юуны өмнө аман зохиолын үндсэн шинжийг үзвэл: Аман зохиол нь:

- Аман уламжлалын шинжтэй
- Хамт олны шинжтэй
- Хувилбарт шинжтэй
- Энгийн шинжтэй

бүтээл бөгөөд эдгээр онцлог шинж нь мэдээ мэдээллийг амаар хэрхэн яаж уламжилж байгаа зүй тогтолоос ихээхэн хамааралтай байдаг. Аман зохиолын дүрслэлийн сэтгэлгээний хэв маяг нь:

○ “Зэрэгцүүлэл” болохоос
“Ахиулал” биш

○ “Нэгдэл” болохоос “Тусгаарлал” биш
бөгөөд үг хэллэг, дүрслэлийн давталт ихтэй, хэвшмэл хэллэг, уламжлалт чанараар баялаг байдаг. Жишээ нь:

Аман зохиолын зүйлийг хэвлэн нийтлэхдээ хэвшсэн дүрслэл, түүний

давтамжийг нурушсан хэмээн үзэж орхих, гээх, засварлах зэргээр үл тоож ирсэн явдал нь чухам бичгийн уран зохиолын сонирхол, бичгийн зохиолыг үнэлэх баримжаанаас үүдсэн зүйл мөн. Учир нь аман зохиолыг ярих, түүнийг сонсох үед, зарим тогтворжсон дүрслэлийн давтагдах байдал нь нуруших, залхаах байдлыг авчирдаггүй харин ч сонирхолтой болгож, аман зохиолыг хүлээн авах явц, харилцан нөлөөлөл, тээгч, сонсогч нарын хоорондын харьцааг нягтруулдаг ажээ. Тухайлбал: Бээжин ший бол дээд хэмжээгээр хэвшин тогтворжсон тоглолтын урлаг ажээ. Үзэгчид Бээжин шийг хөшиг нээгдэж эхлэхээс өмнө уг жүжгийн өгүүлэмж, үйл явдал нь хэрхдэг, ая дан, аялгуу эгшиг, үйл ажиллагааны нарийн ширийн зүйлийг бүгдийг нь мэдчихсэн байдаг. Тэгэхээр энэ бол мэдэхгүй зүйлээ сониучирхан мэдэхийг хүсэх биш, сонирхолтой үйл хэрэг явдлын тухай сониучирхал ч биш, ерөөс үзэгчдийн энэ мэддэг элемент нь тэдэнд урам бах, хүсэл сэтгэлийг нь хөгжөөдөг, татдаг болж байгаа юм.¹

Тиймээс аман зохиол нь хэдий давталт ихтэй, нурушсан, илүүдсэн сунжирсан дүрслэлтэй мэт ч хамгийн боловсорсон


1. Б.Цогжин “Монгол аман туулийн шүлэг зүй” Улаанбаатар, 2010, 65-р тал.

сонгодог хэлбэр болох ба түүний явдал учир, өгүүлэмжийг алгуур урт удаан юм уу хурдан түргэн болгох зэрэг нь ерөөс тухайн тээгч авьяастны ур чадвараас хамаарах зүйл байдаг. Гэтэл бичгийн зохиол нь ийм биш буюу

- Нэгдэлт байдал (*Cohesion*),
- Санаагаа тод илтгэх байдал (*Prominence*),
- Бүтэц, тогтолцоот байдал (*Macrostructure*)

-ыг эрхэмлэсэн, давтагдах чанар багатай бүтээл байдаг. Ийнхүү аман зохиол, бичгийн зохиол хоёр нь хоёр өөр, биеэ даасан тогтолцоотой үгийн урлагийн

төрөл гэлээ ч хоорондоо тусгаар, салангид байсангүй. Харилцан бие биедээ нөлөөлсөн, нэг нэгээсээ уламжилж хөгжсөн “амьд” харилцаа холбоонд оршдог ажээ. Энэ “амьд” харилцаа холбооны бодит жишээ нь аман ба бичгийн зохиолын аль алинд нь байдаг дундын чанартай, шилжилтийн элемент юм. Энэхүү шилжилтийн чанар бүхий элементийн зүйл монголын хүүрнэл зохиолд хэрхэн тусгалаа олсоныг, Д.Нацагдоржийн “Амазонк” буюу олон нийтэд “Хөдөө талын үзэсгэлэн” нэрээрээ түгэн дэлгэрсэн өгүүллэгээр жишээлэн үзье. 1931 онд Д.Нацагдорж “Амазонка”² өгүүллэгээ бичжээ.



Зураг 1. Д.Нацагдорж “Амазонка” өгүүллэг

2. “Амазонк” хэмээх өгүүллэгийн гар бичмэлийг харахад “Амазонк” гэсэн нэрийн ард нь хар балын харандаагаар хашилт дотор <<Хөдөө талын үзэсгэлэн>> гэж бичжээ. Д.Нацагдоржийн зохиолыг хожим хэвлэхдээ чухам энэ нэрээр нь онцлон нэрлэж хэвлэсэн тул ийнхүү “Хөдөө талын үзэсгэлэн” гэж нэрлэжэ заншижээ.

Өгүүллэгт "... Монгол газар минь уудам юмаа. Маи сайхан морьтой юмаа, морио унаад давхихад манай цог заль сэргэнэ. Иийшээ ширтэж, тийшээ гөлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн, ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхэд хэдийн миний хоёр нүд гэрэлтэн туссан бөгөөд нэг залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлээр гарчирэх нь хувилгаан охин адил гэрэлтэй ба цог заль өнгөтэй жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч, зүрхийг чичрүүлэн догдуулж, төв эрдэмт оюутны боловч сүнсийг холбилзуулан татна.

Цагаан саарал морины нуруун дээр ногоон гөлөмтэй боржигон янзын эмээлийг тохсон нь холхи газрын хүлгийн өнгө ялгаран, үзэсгэлэн бүрдээд, түүний дээр залуу охин хормойг цэмцийтэл, гуяыг мөлчийлгөн ороогоод, хөндлөн суужээ.

Үзвэл нас арван найм, ес агаад шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ. Урт хар гэзгийг гурваар даран унжуулж, улбар шар дурдан алчуураар толгойгоо ороон, өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангилан үзүүрийг унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ. Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь улаан туяа тусжээ. Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдэг нимгэнээр хөдлөх тутамд нүд эрхгүй дагалдан давхина.

Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чигчүү дээлийг өмсөн, зүүн ханиуи дотроос нарийхан хурууг цухуйлган, жолоо цулбуурыг хугас барин атгаад баруун ханиуигаа сул тавин, түүний дотор гараа нуун, ташаагаа түлж буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ. Хоолойн

товчийг задгай тавьсан дотуур басхүү хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж буй агаад түүний дотор нимгэн цагаан хөрстэй гуа хүзүү үзэгдэхэд хазаад авмаар буй.

Шар бажгар дурдан бүсийг шавхийтэл ороож, угалзтай шогтгор гутлыг дөрөөний дунд тасхийтэл жийсэн нь талын идэр махбодыг бахархуулжээ. Харь газрын залуу хүн түүний замыг хөндөлдөн саатуулж, хэдэн уг асуун хэлэлцэхэд тал газрын бага охин тэр жолоог татаж, дуртайгаар түдгэлзэн хариулан өчиж басхүү энэ тэрийг лавлан сонирхоно. ..."³ хэмээн өгүүлжээ. Эл бүтээлийг:

• Б.Содном: "Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын хойт уулын энгэрээр нутагладаг айл"⁴

• Г.Жамсранжав: Энэ санааг цааш нь улам "лавшруулан": "Манай утга зохиол судлагчид Д.Нацагдоржийн "Хөдөө талын үзэсгэлэн"-г өгүүлэг гэж нэрлэж иржээ. Гэсэн ч түүнд дүрслэгдсэн зүйл, цаг үе, хэмжээг үзэхэд найруулал шиг санагдана. Энэ санаандаа хөтлөгдөн энэ удаа түүнийг найрууллын төрөл зүйлд хамааруулан тэмдэглэв... Тэгэхлээр уг явдал Хэнтий аймагт болж байдаг. Тэгэхдээ бүр Өндөрхаан хотод болж байгаа бололтой...", "Хэнтий аймгийн Мөрөн, Өндөрхаан сумын аль нэгний харъяат хүн байх, одоо дал орчим насны хүн байгаа даа"⁵

• С.Лочин: "Үнэндээ бол үйл явдал Хэнтий аймаг Өндөрхаан хотод биш Дорнод аймаг Санбэйсийн хүрээнд болж байгаа явдал бөгөөд Өндөрхаан хот биш, Өндөрхаан уулын тухай гарч байгаа юм шүү дээ. Зохиолд морь унасан монгол бүсгүй гэгч хичнээн үзэсгэлэнтэй гоё бөгөөд ямар ч эр хүний сэтгэлийн жолоог алдуулах ид шидтэйг нүднээ харагдаж, сэтгэлд

3. Д.Нацагдорж "Хөдөө талын үзэсгэлэн", "Бүрэн түүвэр" ред. Д.Цэдэв УБ, 1996.

4. Б.Содном "Нацагдоржийн намтар зохиол" УБ.1966, 207-р тал.

5. Г.Жамсранжав "Шинэ замаар", УБ, 1978, 213-р тал.

6. С.Лочин: "Д.Нацагдорж", "XX зууны монгол зохиолчид-I" боть, УБ, 2006, 55-р тал.

шингэтэл яруу дүрсэлснийг үзэж байна.”⁶

хэмээн үзжээ. Өгүүллэгийн агуулгыг зохиолд илэрсэн утгаар нь буюу дээр дурдсан мэтээр тайлбарлаж болох боловч нарратолог⁷ (“*narrataire*” (*fr.*)-ийн үүднээс задлан шинжлэх юм бол ямархуу содон, сонирхолтой шинэ бүтээл болохыг нь гүйцэд ухаарах болно.

Өөрөөр хэлбэл дэлхийн домог үлгэр (*myth*)-ийн сэтгэлгээнд томоохон байр эзэлдэг Амазонкийн домог зүйн өгүүлэмжтэй холбон үзвэл уг бүтээлийн мөн чанар нь илүү тодорно гэсэн үг юм.



Зураг 2. Амазонкчууд хийгээд Грекчүүдийн тулалдаан. Уран баримал

Амазонкууд бий болсон түүх нь эрчүүд бүхий өөр улс түмэнтэй холбоотой. Хэрэв амазонк эмэгтэйгээс хүү төрөхөд эцэг рүү нь явуулдаг, (*домог үлгэрийн зарим хувилбарт “шүүд алдаг”*) үүндээ маш үнэнчээр ханддаг, охин төрвөл үлдээж шинэ амазонкыг хүмүүжүүлдэг. Ингэхдээ өсвөр насанд нь нэг хөхийг нь тасддаг ажээ. Энэ нь нум сум харвахад саад болохгүй гэж үздэгтэй холбоотой буюу тиймээс

“Амазонкийн домог үлгэр” нь 3000-гаруй жилийн тэртээгээс яригдсаар өнөөдөртэй золгожээ. Амазонка гэдэг үг нь эртний Грекийн “**Хөхгүй**” гэдэг утгатай үг бөгөөд Амазонкчууд нь толгойдоо шовгор малгай шиг дуулгатай, баруун хөхгүй (*баруун хөхөө авахуулсан, тайруулсан, тасдуулсан*), зүүн хөх нь ил, бусад биеэ халхалсан тулааны зориулалт бүхий өмсгөлтэй, урт өргөн бүстэй, ороонго өвс мэт бамбайтай, исгэрч дуугардаг олс мэт зүйл гартаа барьж явдаг ЭМЭГТЭЙЧҮҮД байдаг ажээ.




Зураг 3. “Шархадсан Амазон” уран баримал. Капитолийн музей, Итали, Ром хот

“Амазонки” буюу “Хөхгүй” гэдэг нэр үүсэн дэлгэрсэн бололтой.

Харин Амазонкийн домог үлгэр гэдэг нь ийм эмэгтэйчүүдийн тухай буюу өөрсдийн өмнө эрчүүдийг хүлээн зөвшөөрдөггүй, тулаанч, дайнч баатарлаг зоригт хатан хаантай, эмэгтэйчүүдийн бүлгийн тухай өгүүлдэг Эртний грекийн домог үлгэр (*myth*)-ийн, домог зүйн бүтээл юм.

7. Уран зохиолын өгүүлэгчээр нь хөөж өгүүлэмжийг нь тогтоодог арга зүйн тогтолцоо. “*Narrataire*” гэдэг нь франц хэлний үг ба өгүүлэгчийн хэнд хандаж буйг холбоог заасан утгатай. Зохиолд зохиогч чухам өөрийн үзэл зорилго, үнэлэлт хэмжүүр, дуу хоолойгоо илтгэдэг. Үүнд үндэслэн зохиолын өгүүлэмжийг тогтоодог арга болно. (Ч.Билигсайхан “Ухаарахуй”).



Зураг 4. Эртний Грекийн домог. Геракл баатар болон Амазонны тулааныг үзүүлсэн вааран дээрх зураг.

Домог үлгэрт тэднийг уран сайхны дүрээр тусгахдаа гол төлөв эртний грекийн урлагийн хэв маягаар, маш сайхан төгс төгөлдөр, хоёр хөхтэй эмэгтэйгээр дүрсэлсэн байдаг. Гэхдээ булчингийн хөгжлийг нь илт товойлгосон бурханлиг ариун дүртэй боловч дайчч эмэгтэй гэдэг нь мэдэгддэг ажээ. Тэгвэл Д.Нацагдорж “Амазонка”-доо чухам Амазонкийн домог үлгэрт гардаг шиг тийм эмэгтэйг дүрсэлсэн юм. Амазонкийн домгийн дүрслэлийн үндсэн формула (*Formul-үндсэн буюу хэвшилт өгүүлэмж, дүрслэл*)-нь Амазончууд бол маш тэнгэр бурханлиг байх ёстой, үүний зэрэгцээ үзэсгэлэн төгөлдөр эмэгтэй байх ёстой. Мөн бие бялдарын хөгжил хөдөлгөөн сайтай байх ёстой. Дөнгөж саяхан эх оронд маань болсон

“*Face of Beauty International 2016*” наадмын шүүгчээр ажилласан, дэлхий дахинаа “*Амьд барби*” нэрээрээ алдаршсан Украйны дуучин, жүжигчин, загвар өмсөгч Валерия Лукьянова монголын сэтгүүлчийн асуусан асуултын хариу болгож:

“Гоо сайхандаа бас тийм ч сэтгэл хангалуун байдаггүй. Миний үзэл бодол өөрчлөгдөж байна. Надад амазон бүсгүйчүүд их таалагддаг болсон. Эмэгтэй хүн булчинлаг харагдах нь гоё юм билээ. Тиймээс гадаад төрхөндөө төдийлөн

сэтгэл хангалуун байдаггүй. Ямартай ч би булчинлаг болохыг эрмэлзэж, өөртөө таалагдахын тулд ойролцоогоор дахиад нэг жил орчим биеэ хөгжүүлэх хэрэгтэй байна.”⁸ хэмээн өгүүлсэн байна. Түүнчлэн Амазончууд өөрийн өмнө эрэгтэй хүнийг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй, маш золбоолог хийморлиг эмэгтэй байдаг байна. Тэгвэл Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн”-д чухам ийм эмэгтэйг дүрсэлэн харуулсныг дараах жишээнээс үзэж болно. Үүнд:

- Бурханлиг шинж “... нэг залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэх нь хувилгаан охин адил гэрэлтэй ба цог заль өнгөтэй жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч, зурхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюутны боловч сунсийг холбилзуулан татна.”

- Гоо үзэсгэлэнт байдал: “... зүүн ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган ...”, “Хоолойн товчийг задгай тавьсан дотуур басхүү хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж буй агаад түүний дотор нимгэн цагаан хөрстэй гуа хүзүү үзэгдэхэд хазаад авмаар буй.”, “Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь улаан туяа тусжээ. Харах нүдний хар цагаан нь хослоод, ... залуу хүний дээр эелдэг нимгэнээр хөдлөх тутамд нүд эрхгүй дагалдан давхина.

- Булчингийн хөгжлийг нь илт товойлгосон: “Цагаан саарал морины нуруун дээр ногоон гөлөмтэй боржигон янзын эмээлийг тохсон нь холхи газрын хүлгийн өнгө ялгаран, үзэсгэлэн бүрдээд, түүний дээр залуу охин хормойг цэмцийтэл, гуяыг мөлчийлгөн ороогоод, хөндлөн суужээ.”, “Шар бажгар дурдан бүсийг шавхийтэл ороож, угалзтай шогтгор гутлыг дөрөөний дунд тасхийтэл жийсэн нь талын идэр махбодыг бахархуулжээ.

- Эрчүүдийг хүлээн зөвшөөрдөггүй: “Харь газрын залуу хүн түүний замыг хөндөлдөн саатуулж, хэдэн үг асуун

8. “Валерия Лукьянова: Намайг “Барби” гэж дуудахад дургүй, гэхдээ...”, <http://news.gogo.mn/r/193912>.



хэлэлцэхэд тал газрын бага охин тэр жолоог татаж, дуртайгаар түдгэлзэн хариулан өчиж...”

• Золбоолог хийморлиг байдал: “... Хэрлэн голын хөвөөн дээр нэг эрэн майхан бүрэг бараг үзэгдэхийг заагаад, даруй морио ташуурдан харайлгаж, исгэрэн харайлгасаар одов.” гэжээ. Ийн үзвэл өгүүллэгт дайчин баатарлаг жавхаалаг эмэгтэйчүүдийн бүлэг - Амазонкчуудын үндсэн имиж, дүр төрхөөр үзэсгэлэнт монгол эмэгтэйг зуран өгүүлсэн нь илэрхий байгаа юм. Тэгэхээр эл бүтээл яах аргагүй Амазонка хэмээх онцгой нэгэн овгийн тухай өгүүлдэг домог зүйн сэтгэлгээтэй уламжлалын холбоотой ХХ зууны монголын уран зохиолын туурвил зүйн туршлага болох нь илэрхий байна.

Нөгөө талаар ийм баатарлаг жавхаалаг эмэгтэйчүүдийн тухай домог зүйн сэтгэлгээ нь зөвхөн өрнөдийн аман зохиолд байдаг бус ази, дорно дахины улс үндэстний аман зохиолд ч байдаг үзэгдэл гэдгийг дурдах хэрэгтэй. Тухайлбал БНХАУ-ын Гансуй мужийн Баруун хойд үндэстний их сургуулийн профессор Д.Батын 2012 оны 6-р сарын 13-ны өдөр, Агваанчойдор агснаас тэмдэглэсэн нэгэн домогтой танилцъя.

«Төвдийн зүүн өмнө тал, Сцован мужтай хил залгаж байгаа нэгэн газрыг Гунбокуг буюу *ngon ro khog*, *хятадаар* Лин хи (林芝) гэдэг. Энэ газар нь ер эрэгтэй хүнгүй дандаа эмэгтэй хүмүүс байдаг (хүүхэд гарвал эмэгтэй хүүхэд гардаг) болохоор тэр газрын хүмүүсийг төвдийн түүхэн дээр “Эм улс” гэж нэрийддэг ажээ. Мөн саяхан болтол тийм хэвээрээ байв. Жишээ нь: Дундад иргэн улсын үе (1912-1949)-д Сцованыг захирч байсан цэргийн эрхтэн Жуу Эл Фен (赵尔丰 1845-1911) Төвд рүү дайн хийгээд буцаж явах замдаа түүний олон цэрэг нь энэ Эм улсад баригдаж, гарч чадалгүй тэндээ хоцорсон гэдэг ажээ. Урьд тэр газарт эрэгтэй хүн орвол барьж аваад явчихдаг.

Нэг орвол гарч ирэх аргагүй тэндээ байж байгаад үхдэг гэж хэлэлцдэг болохоор Зууд мөргөхөөр явж байгаа хүмүүс маш хичээж, маш их бэлтгэлтэй явдаг байв»⁸ гэжээ. Мөн үүнээс гадна Б.Ринченгийн “Их нүүдэл” романыг ч анхаарахгүй орхиж болохгүй. Романд өрнөдийн аман уламжлалын нэгэн сонгодог жишээг шигтгэл хэлбэрээр оруулсан байдаг.

“Хоёр зуу гаруй жилийн тэртээ персийн эзэн Хистаспын дараа төр барьсан Дариус гэдэг сүр их хүчин төгөлдөр эзэн нь скит улсыг дайлаар их цэрэг хөдөлгөн, скит нутагт халдан орж ирсэн гэдэг. Тэхэд скитийн тэргүүн олон ноён, шар үстэй, цэнхэр нүдтэй бүдин гэдэг аймгийн эздээс тусламж эрж, нарсан ойд модон байшинд суудаг тэдний зүг элч явуулж, Танаис ид мөрний тэртээх савромад гэдэг нүүдэлчин улсаас цэргийн тусламж хүсэн, тэр савромад улсын эмс охид **хүртэл баатар** их зоригтой тул, **персийн Дариус** эзний **их цэрэгтэй** тулахад нэгэн **мөрний хүч түшиг болно** гэж **скитүүд** их итгэдэг байж гэнэ. **Савромад улсын эрс, наад** зах нь нэг дайсныг алаагүй **хүүхнийг хүн гэж үздэггүй** тул, дайнд яваагүй охин **хүн бол эрлиг аваачихаас** эр олддоггүй, тийм дайчин улс **биш байжээ**. Тэгээд персийн их цэрэг скит нутагт **нэвтрэн ороход зах** нийлсэн улсын туслах цэрэг ирэхийг **хүлээж** адуу малтайгаа, тэрэгтэй гэртэйгээ зайлан **нүүж дайсны** замд тохиолдох худаг усанд хор хийж, **хээр талд түймэр** талбин зайлж, Идайтирис гэдэг **тэргүүн ноён** хашир дайчин эрээр удирдуулан уудам нутагтаа **хүч** хуралдуулан нүүж байсан гэдэг” хэмээжээ. Ийнхүү манай ахмад зохиолч уран бүтээлчид домог зүйн ийм нийтлэг үзэгдлийг өөрсдийн бичгийн зохиолдоо шингээн дүрсэлж, тодорхой хэмжээгээр танилцуулсаар ирсэн нь уран сайхны туурвил зүйн сэтгэлгээний ололт болсоор ирсэн гэж баттай хэлж болох ба туурвил зүйн сэтгэлгээний ийм нэгэн

8. Д.Бат эмхэтгэн найруулав “Агваанчойдор гуайн ярьсан аман түүх хийгээд Халх Ойрдын зарим түүхт хүмүүсийн домог”, 2016.

илрэлийг Д.Нацагдоржийн “Амазонк” болж байна. Ийн дүгнэхэд:

1. Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд ялангуяа урлагийн туурвил зүйн сэтгэлгээнд аман зохиол бичгийн зохиол хоёр нь ямагт харилцаа холбоо, харилцан нөлөөлөлийн амьд орчинд оршиж иржээ.

2. XX зууны монголын хүүрнэл зохиолын уран сайхны туурвил зүйн туршлагад өгүүлэмжээ нээх, зохиолынхоо явдал учир шалтгааныг үзүүлэх, бэлгэдлийн хүрээнд ашиглах ... зэрэгт домог зүйн өгүүлэмж, домог үлгэрийн сэтгэлгээ нөлөөтэй хэвээр байгаа нь харагдаж байна.

3. XX зууны сүүл XXI зууны эхэн үеийн энэ цаг үед хуучны зүйл, эрт үеийн туурвил зүйн сэтгэлгээ, эртний соёлд хандах нийгмийн сэтгэлгээ, дэлхий дахины хандлага илт сэргэж, өнгөрснийг судлан тогтоох нь ирээдүйгээ танихийн үндэс гэдгийг ухаарсан, тэр хэрээр хуучныг дээдлэх, хуучнаас эх үндсээ авах, харилцаа холбоотой байх эрмэлзэл, сэтгэлгээ хүчтэй дэлгэрч байна. Жишээ нь: Ардын урлаг, уран сайхны язгуур сэтгэлгээ дэлгэрч байна. Эртний хүмүүсийн бүтээсэн урлагийн зүйлс тухайлбал хадны сүг зураг, элдэв хээ дүрс энэ цагийн гоёл, чимэглэл, дизайны урлагтай хавсарч, шинэ цагийн модерн шинж бүхий байдалтай болж байна. Ардын дуу хөгжмийн урлаг орчин үеийн урлагтай хавсарч өвөрмөц хэв маягийг бий болгож байна. Орчин үеийн хөгжмийн *hip hop* юм уу *beatbox* маягийн хэлбэрийн уламжлалыг ардын урлаг соёлоос хайвал илүү үр дүнд хүрч болно.

Энэ бүхнээс үзвэл нийлэг чанар,

даяаршил, интеграци, нэгдмэл соёлын хүрээ улам өргөжих нь илэрхий бөгөөд соёл, уран бүтээл, туурвил зүйн сэтгэлгээнд салангид тусгаар бус, хил хязгааргүй нийтлэг сэтгэлгээний чанар илүү оршин тогтнох чадвартай болох нь харагдаж байна.

4. XXI зуунд аман зохиолын зүйлээс домог зүйн сэтгэлгээ хүчтэй түгэх болов уу. Учир нь нэг талаар дээр дурдсан байдалтай холбогдоод, нөгөө талаар ерөөс үгийн урлагийн эх нь домог зүй байдаг уламжлалын дагуу уран зохиолд шинэ агуулга, шинэ төрөл хэлбэр үүслээ гэхэд тэрхүү шинэ бий болсоу зүйлийн ихэнх нь дооног зүйтэй, домог үлгэрийн сэтгэлгээтэй холбоотой байх дүр зураг тодорч байгаа юм.

Домог зохион яригчид нь өөрсдийгөө зохиогч хэмээн ухамсарладаггүй байжээ. Тэдний уран бүтээл ухамсаргүй буюу ухамсарлагдаагүй байсан хэрэг юм. Домог зохиогчид нь өөрсдийгөө өгүүлэмжид дотроо оруулан сэтгэж байсан учраас тэд түүнийг задлан шинжилж чадахгүй, домог үлгэр зохиож байгаагаа өөрөө мэддэггүй байсантай адилхан цаг үе бидний үед тохиож байх шиг. Жишээ нь: Нийгмийн үзэл санаа, үнэт зүйл солигдох, өөрчлөгдөх, шилжихэд түүнийг хүлээн авах, түүнд дасан зохицох нийгмийн сэтгэлгээ хараахан бүрэлдээгүй байгаа зурвас үед домог зүйн сэтгэлгээ асар хүчтэй дэлгэрдэг ажээ. Үүнийг 1980-аад оны сүүл 1990-ээд оны эхэн үеийн Монгол орны байдал бэлхэнээ харуулсан билээ. (алтан цөгц, харь гариг, биеэсээ гал гаргадаг гэдэг, газар доорх могой гм)